



**БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 11 сарын 07 өдөр

Дугаар A/10

Улаанбаатар хот

Бараа материал актлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 31 дүгээр зүйлийн 31.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Малын эмчийн дүгнэлт, байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу байгууллагын эргэлтийн хөрөнгийн мал амьтад дансанд бүртгэлтэй нийт 3,122,452 /гурван сая нэг зуун хорин хоёр мянга дөрвөн зуун тавин хоёр / төгрөгийн үнэ бүхий дөрвөн толгой үхрийг данс бүртгэлээс хасаж актлах жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Данс бүртгэлээс хасагдсан бараа, материалыг устгах ажлыг холбогдох хууль, журмын дагуу Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохион байгуулж, дүнг танилцуулахыг Нягтлан бодогч (Ц.Мөнхдөл)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төслийн менежер (Ц.Цогтгэрэл)-д даалгасугай.


ДАРГА



Н.УУГАНБАЯР

3140000011

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж”
орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн
газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын
07-ны өдрийн 110 дугаар тушаалын хавсралт



БАРАА МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

№	Бараа материал	Нэг бүрийн үнэ	Бүртгэлийн дугаар	Код	Зүс	Тоо толгой	Дүн
1	Дөнж	1,297,500	00001052	18406	Улаан	1	1,297,500
2	Тугал /эр/ 2023	470,000	00001071	33193	Хүрэн	1	470,000
3	Тугал /эм/ 2022	599,952	00001056	18405	Ягаан халзан	1	599,952
4	Бяруу 2022	755,000	00001055	18367	Улаан	1	755,000
	Дүн					4	3,122,452